



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.21 № 3/497
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөлт нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 16 “Үндсэн хөрөнгө”-тэй нийцэхгүй байгаа ба үүнээс үүсэх үр нөлөө нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В. М.

Ц.НАРАНЧИМЭГ



“ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Газрын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас :261885
Цахим хаяг: sambuunyamy@audit.mn

Монгол Улсын Үндэсний Аудитын газар
Монгол Улс, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: www.mnao.mn



Гроут финанс аудит ХХК

Гүйцэтгэх захирал
Б.Бямба
Аудитын менежер: Э.Мөнхтогтох
Аудитор: Т.Ариунжаргал, Б.Даваасүрэн
Утас. 99094391,91913664

Цахим хаяг:
info@growthfinance.mn

Гроут финанс Аудит ХХК-ийн хаяг:
Улаанбаатар 16030, Баянгол дүүрэг,
Энгельсийн гудамж 11-191 тоот

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Зорилтот түвшний биелэлт

АГУУЛГА

Хуудас

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
2. Компанийн хууль, эрх зүйн орчин	4
3. Компанийн зорилго, үйл ажиллагаа	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	5
5. Материаллаг байдал	5
6. Дотоод хяналт	5-6
7. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	6
8. Шилэн дансны мэдээлэл	6-7
9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар	7-8
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	8-9
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	10-12
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	12-14
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15-16
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	16
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	16
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
17. Аудитын дүгнэлтийн санал	17

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

“Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.2дахь заалтыг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/93 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу **“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК**-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд (САГ/2017/46/СТА-ТӨҮГ) аудит хийлээ.

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандарт, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын гарын авлага, Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэм, аудитын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бусад дүрэм журмыг мөрдөж ажиллан төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулсан.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), түүнд нийцүүлэнгаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Компанийн удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн компанийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын компанийнүүрэг юм.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр анхны уулзалтаа хийж аудитын ажилд шаардлагатай материалын жагсаалтыг хүргүүлж эхлүүлсэн бөгөөд 2016 оны 11 дүгээрсарын 21-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийг хүртлэх хугацаанд завсарын хугацааны аудитын ажлыг, 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдрийг хүртлэх хугацаанд жилийн эцсийн аудитыг гүйцэтгэхээр төлөвлөн аудитын менежерээр ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй аудитын баг гүйцэтгэсэн.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХКнь 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын15-ны өдөр Гроут финанс Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Гроут финанс Аудит ХХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр**“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК**-ийн удирдлагад гардуулна.

2. Компаний хууль, эрх зүйн орчин

Тус компаний удирдлага нь Монгол Улсын доорх хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

- ✚ Иргэний тухай хууль
- ✚ Компанийн тухай хууль
- ✚ Эрчим хүчний тухай хууль
- ✚ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- ✚ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✚ Төсвийн тухай хууль
- ✚ Төрийн аудитын тухай хууль
- ✚ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ✚ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✚ Хөдөлмөрийн тухай хууль
- ✚ Татварын багц хууль
- ✚ Нийгмийн даатгалын тухай хууль
- ✚ Аудитын тухай хууль
- ✚ Байгаль орчныг хамгаалах тухай хууль

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 1983 онд байгуулагдсан бөгөөд “Эрчим хүчний тухай” хууль, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу тус компанид Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2004 оны 49 дүгээр тогтоолоор цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, 2006 оны 106 дугаар тогтоолоор цахилгаан үйлдвэрлэх, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлүүдийг олгосон. Эдгээр тусгай зөвшөөрлийн дагуу цахилгаан, дулааныг үйлдвэрлэж, түгээх үйл ажиллагаа эрхэлж байна.

Тус компани нь цахилгаан, дулааны эрчим хүчийг хамгийн бага зардлаар үйлдвэрлэн нийлүүлэх, эрчим хүчний үйлдвэрүүдийн хөгжлийг тодорхойлогч байх эрхэм зорилго тавин ажиллаж байна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 71.2 хувь, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 52.1 хувийг дангаар хангадаг Монгол улсын эрчим хүчний хамгийн том үйлдвэр юм. Тус станцын харъяанд 3-20 км алслагдсан үнс хадгалах сан болон техникийн ус хангамжийн насос станц мөн түүнчлэн ахуй үйлчилгээний, инженерийн, лаборатори туршилтын төв зэрэг 66.7 га талбай бүхий 70 гаруй барилга байгууламж багтдаг.

2016 оны байдлаар нийт 1477 ажиллагсадтай байгаагийн 272 инженер техникийн ажилтан байна.

2001 оны 8 дугаар сараас Төрийн өмчийн хувьцаат компани болж, хувьцааны 41 хувийг Эрчим хүчний яам, 39 хувийг Төрийн өмчийн хороо, 20 хувийг Сангийн яам тус тус эзэмшиж байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашигласан.

Аудитаар “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК -ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн компанийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 88-г гүйцэтгэв.

Тухайн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимтой танилцахад санхүүгийн үйл ажиллагаандаа СТОУС болон Сангийн яамнаас баталсан заавар журмын хүрээнд өөрийн компанийн онцлогийг тусган боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг (НБББББ)захирлын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/71 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.2016 онд энэхүү НБББББ-нд СТОУС болон хууль дүрмийн өөрчлөлтийг тусган шинэчлэж байгаа бөгөөд хараахан удирдлагаар батлуулан мөрдөж эхлээгүйбайна.

Мөн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаагбүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагаагERP програмаарболовсруулж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.Энэхүү програмнь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа төдийгүй худалдан авалт, төлөвлөлт, хүний нөөц, засвар, ТЭЗҮ, борлуулалтын модультай уялдан ажиллажбайна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийнүйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

5. Материаллаг байдал

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийж байгаа бөгөөд 220,601.7 сая төгрөгийн нийт орлогыгматериаллагийн түвшиний суурь болгон нийт орлогын 0.5 хувиар тооцон1,103.0 сая төгрөгөөр материаллагийн түвшинг тогтоосон. Гүйцэтгэлийн үе шат болон дуусгалтын үе шатанд материаллагийн түвшинд өөрчлөлт гараагүй болно.

6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа

гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус компанийн дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын эрсдэл дунд гэж үзлээ.

7. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 2016 онд 217,797.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 216,780.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Борлуулалтын орлогыг орлогын төрлөөр ангилан үзвэл цахилгаан эрчим хүч борлуулалтын орлого 179,981.8 сая төгрөг, дулааны эрчим хүч борлуулалтын орлого 36,799.1 сая төгрөг байна. Борлуулалтын орлогыг өнгөрсөний мөн үетэй харьцуулан үзэхэд 21,391.5 сая төгрөг буюу 10.9 хувиар өссөн, төлөвлөгөөтэй харьцуулахад 1,016.3 сая төгрөг буюу 0.46 хувиар буурсан байна.

Тус компани нь тайлант онд 212,091.2 сая төгрөгийн борлуулалтын өртөгтэй ажилласан байгаа нь өмнөх оны дүнгээс 20,967.1 сая төгрөгөөр өссөн байгаад борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн өсөлттэй уялдсан түлшний зардлын өсөлт, ажилчдын цалингийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна. Хувьсах зардал буюу түлшний зардал төлөвлөгөөнөөс 1,960.7 сая төгрөгөөр буурч, тогтмол зардал 1,342.7 сая төгрөгөөр нэмэгдсэн ба нийтдээ үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөтэй харьцуулахад 1,929.6 сая төгрөгөөр буурсан байна. Үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөтэй зардлын төрлөөр харьцуулан үзэхэд сэлбэг хэрэгслийн зардал 0.8 сая төгрөгөөр, байгууллагаас төлөх НДШ-ийн зардал 72.0 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Тайлант онд үндсэн бус үйл ажиллагаанаас 4,972.6 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөтэй харьцуулахад 1,500.7 сая төгрөгөөр өссөн ба 9,620.4 сая төгрөгийн зардалтай ажилласныг төлөвлөгөөтэй харьцуулан үзэхэд 5,852.1 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Үйл ажиллагааны бус зардлын өсөлтөд валютын ханшийн алдагдал 5,141.5 сая төгрөг, ажиллагсдын нийгмийн зардал 437.0 сая төгрөг, бусад зардал 278.2 сая төгрөг тус тус нөлөөлсөн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах дотоод журам”-ыг 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн гүйцэтгэх захирлын А/25 дугаар тушаалаар батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус хуулийн 5.1-т заасны дагуу “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК” нь өөрийн цахим хуудас болох <http://www.tpp4.mn/> сайтад шилэн дансны бие даасан цэс дараах мэдээллийг байршуулан ажиллаж байна.

-  Сар бүр гаргасан тушаал шийдвэр, байгуулсан гэрээ
-  Тендер шалгаруулалтын мэдээлэл
-  Худалдан авах үйл ажиллагааны тайлан

Компани нь хуулийн дагуу дээрх мэдээллийг тогтсон цаг хугацаанд шилэн дансны бие даасан цэс болон байгууллагын вэб хуудас, мэдээллийн самбарт байршуулснаар компанийн удирдлага, хамт олон болон олон нийтийг компанийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлсэн.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 29-н эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Олж тогтоосон эрсдлийн үр дагаврыг тодорхойлвол:

- Авлагын дансны хувьд авлагын насжилтын тайлан гаргаж судалгаа хийгээгүй байх, найдваргүй авлагын нөөцийг байгуулах хувь хэмжээг үндэслэлгүй тогтоосон байх, найдваргүй авлагын нөөцийн тооцооллыг буруу хийх, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг эрсдлүүд байж болзошгүй гэж тогтоосон. Үүний дагуу дансны нарийвчилсан сорил гүйцэтгэхэд найдваргүй авлагын нөөцийн тооцооллыг НБББББ тусгасанаас зөрүүтэй тооцсон байгааг илрүүлж санхүүгийн тайланд залруулан зөвлөмж хүргүүлсэн.
- Бараа материалын дансад хэрэгцээ шаардлага хангахгүй, насжилт өндөртэй бараа материал байх, бараа материалын тооллого хийгээгүй байх, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байх, бараа материалын үнэ цэнийн бууралтыг бүртгээгүй байх, бараа материалын худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээг худалдан авах тухай хууль, худалдан авалтын журмыг мөрдөөгүй гүйцэтгэх эрсдэл үүсч болзошгүй гэж үзсэн. Олж тогтоосон эрсдлийн дагуу дансны нарийвчилсан горим гүйцэтгэхэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр гараагүйгээс бараа материалын тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд актлах 202 нэр төрлийн 209.3 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа төдийгүй нүүрснээс бусад бараа материалын насжилтын судалгааг гаргахад бараа материалын 58.3% нь 3 ба түүнээс дээш жилийн насжилттай, эргэлтгүй хөрөнгө байгааг тогтоож бараа материалын нөөцийг зохистой бүрдүүлэх, хэрэгцээнээс илүү бараа материалын нөөц бий болгохгүй байх үүдээс сэлбэг хэрэгсэл, материал үнэт зүйлсийн захиалга, татан авалтын төлөвлөлтийг сайжруулах, үлдэгдлийг зохистой түвшинд байлгах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлсэн. Мөн тайлант онд дэлгүүрт 361.5 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байгаач худалдан авалтад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээг худалдан авах тухай хууль, худалдан авалтын журмыг мөрдөөгүй байгаад зөвлөмж хүргүүлсэн.
- Үндсэн хөрөнгө элэгдүүлэх хугацааг НББОУС- 16-д заасны дагуу тогтоогоогүй байх, үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй байх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө худалдан авах, үндсэн хөрөнгийн элэгдэл болон их засварыг буруу тооцон бүртгэх, үндсэн хөрөнгийн өртгийг буруу тооцох, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байх, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байх зэрэг эрсдэл байж болзошгүй гэж төлөвлөлтийн үе шатанд тогтоосны дагуу нарийвчилсан горим, сорил гүйцэтгэхэд тус компани нь

хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаатай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, хөрөнгийн элэгдэл, бичиг хэрэг, харилцаа холбоо зэрэг зардлуудыг 2040-тэй дансад хуримтлуулан бүртгэж, үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээлгэн өгөх үед хөрөнгийн өртөгт бүртгэж байгааг, урсгал засварын шинжтэй материал, засварын зардлыг үндсэн хөрөнгийн дүнд капиталжуулан бүртгэж байгааг, шинээр худалдан авч буй үндсэн хөрөнгийг санхүү бүртгэлд тусгахдаа үндсэн хөрөнгийн орлогын модулиар бус бараа материалын дансаар дамжуулан бүртгэж байгааг, НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн шаардлага хангасан ашиглаж байгаа хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байгааг илрүүлж зөвлөмж, залруулгыг санал болгосон. Мөн үндсэн хөрөнгийн дансад бүртгэлтэй ашиглах боломжгүй, хэрэгцээ шаардлага хангахгүй 587 ширхэг, 125.2 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хөрөнгийг актлахаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гарсанч Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын шийдвэр гараагүйгээс санхүүгийн тайланд үр дүнг тусгаагүй.

- Цалингийн зардлын хувьд батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулах, нийгмийн даатгал, татварын тайлангаас зөрөх, илүү цагийн хөлс болон бусад нэмэгдэл шагнал урамшууллыг зөв бүртгэхгүй байх, бусад нэмэгдэл урамшууллыг хамтын гэрээ болон бусад хууль тогтоомж зөрчин олгох зэрэг эрсдэл байж болзошгүй гэж үзэн аудитын нарийвчилсан сорил горимыг хэрэгжүүлэхэд цаг бүртгэлийн ERP системийг бүрэн ашигладаггүй, Хамтын гэрээнд өөрчлөлт ороогүй байхад илүү цаг тооцох тарифт цалинг өөрчилсөн, Хамтын гэрээ болон Хөдөлмөрийн тухай хууль зөрчин илүү цагаар ажиллуулсан зэрэгт зөвлөмж хүргүүлсэн.
- Тэтгэмж урамшууллын зардлын хувьд батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулах, татвар шимтгэлийг буруу тооцох эрсдэл үүсч болзошгүй гэж төлөвлөсний дагуу шалган үзэхэд Хамтын гэрээний дагуу олгож буй зарим тэтгэмжээс ХХОАТ суутгаагүй, ажлаас халагдсаны тэтгэмжийг 3,6,12 саруудаар харилцан адилгүй олгож байгаад зөвлөмж хүргүүлсэн.

Эдгээр нь эрх ба үүрэг, үнэн зөв, оршин байгаа, тохиолдсон байх, үнэлгээ, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК”-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, орлого, өртөг, цалингийн зардал, үйл ажиллагааны бус орлого, зардал зэрэг дансад ажил гүйлгээ, үлдэгдэл тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим сорилын аргаар шалгалаа.

Мөн мөнгөн хөрөнгийн дансдын үлдэгдлийг тулган шалгах, авлага өглөгийн үлдэгдлийг тулган баталгаажуулалтаар нотлох, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хяналтын түүвэр тооллого хийх, тодорхой ажил гүйлгээг түүвэрлэн сорил хийн шалгах, орлого,

өртгийн дүнд шинжилгээ хийх, таамаглах, татвар нийгмийн даатгалын тайлангуудыг нэгтгэн холбогдох данс руу хөөн шалгах горимыг гүйцэтгэсэн.

✚ Монгол Улсын Засгийн газрын бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 120 МВт-аар өргөтгөх төслийн хүрээнд суурилуулсан 141,072.5 сая төгрөгийн өртөг бүхий **“Турбин агергат 7”**-г 2015 оны 12 дугаар сард Улсын комиссын актыг хүлээн авснаар 2015 оны 12 дугаар сарын 1-нд үндсэн хөрөнгөнд, эх үүсвэрийг эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансад бүртгэсэн. Улмаар хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 05 дугаар тогтоолоор эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 135,862.2 сая төгрөгөөр төрийн өмчийг буюу хувьцаат капиталыг өсгөсөн байна. Хэдийгээр НББОУС 20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын тусламжааны тодруулга”-д засгийн газрын буцалтгүй тусламжийг капиталын аргаар бүртгэх нь нээлттэй боловч Эрчим хүчний зохицуулах хорооноос засгийн газрын буцалтгүй тусламжийг орлогын аргаар бүртгэх талаар тус компанид шаардлага ирүүлж, капиталын аргаар бүртгэх тохиолдолд **“Турбин агергат 7”** хөрөнгийн элэгдлийн зардлыг тариф суулгах боломжгүй гэж үзсэн байна.

✚ **Эрчим хүчний үр ашиг II төслийн** хүрээнд: Турбины конденсаторын хоолойг ажиллагааны явцад нүхтэрсэн бөмбөлөгөөр цэвэрлэх технологи бүхий тоног төхөөрөмжийг турбингенератор 1,2,3,4,5,6-д суурилуулах, хөргөлтийн усны Д-1600 мм голчтой 4 ш ерөнхий шугам тус бүр дээр автомат ажиллагаатай шүүлтүүр тавих төслийн 1-р багцын ажил дуусч 2016 оны 5 дугаар сард Улсын комисс хүлээн авснаар үндсэн хөрөнгөнд бүртгэж дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 3.9 сая еврогийн зээлийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Төслийн 3-р багцын ажил болох дотоод циклийн усыг “Эсрэг осмос + цахилгаан деионизаци”-ийн технологээр бэлтгэх тоноглол суурилуулах ажил 2013 оноос хэрэгжиж 2014 оны 11 дүгээр сараас ашиглаж эхэлсэн хэдий ч 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Техникийн комиссын акт гарч, Улсын комисст хүлээлгэн өгөөгүйгээс хөрөнгө болон дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 3.5 сая еврогийн зээлийн өр төлбөрийг бүртгээгүй.

✚ **Хөрөнгийг элэгдүүлэх** Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 1/250 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох” журмыг баримтлан үндсэн хөрөнгийг элэгдүүлэх ёстой боловч Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифтай уялдуулан компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүнд тохируулж үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцон, бүртгэж байгаатай холбоотой санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн үлдэгдэл өртөг, элэгдэлийн зардал материаллаг зөрүүтэй илэрхийлэгдэхэд хүрч байна.

11. Аудитаар илрүүлсэн зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад илэрсэн материаллаг хэмжээний алдааг дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

1. **Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн бүртгэл:** “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-ний 12.1-ийн дагуу << тус компанид сүүлийн 10 жил тасралтгүй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарахаар ажлаас чөлөөлөгдсөн хүнд эрчим хүчний салбарт ажилласан бүх жилийг оролцуулан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг >> олгож байгаач энэхүү тэтгэмжийг НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр тэтгэмж”-ийн дагуу бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил эрхлэлтийн дараах нэг удаагийн тэтгэмжийг НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр тэтгэмж”-ийн дагуу тооцон санхүүгийн тайлан, дэлгэрэнгүй орлогын тайланд залруулан бүртгэж *Зөвлөмж* хүргүүлсэн.

2. **Ашиглаж эхэлсэн боловч хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй хөрөнгө ба хамаарах зээлийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт:** 2010 оноос хойш тус компанийн дотоод циклийн усыг “Эсрэг осмос + цахилгаан деионизаци”-ийн технологиор бэлтгэх төслийн судалгаа явагдаж улмаар Эрчим хүчний үр ашиг II төслийн хүрээнд 3.75 сая еврогоор санхүүжүүлэх Засгийн газрын шийдвэр гарсан байна. Төслийн тендерийг 2013 оны 3 дугаар сард олон улсад нээлттэй зарлаж БНХАУ-ын Нари Футонг компани гүйцэтгэгчээр шалгарч 2013 оны 8 дугаар сарын 16-нд гэрээ байгуулан төслийн угсралт суурилуулалтын ажил эхлэн 2014 оны 11 дүгээр сарын 19-нд албан ёсоор хүлээн авч ашиглаж эхэлсэн байгаач Улсын комисст хүлээлгэн өгөөгүйгээс өнөөдрийг хүртэл энэхүү тоноглолыг үндсэн хөрөнгөд орлого аваагүй, дуусаагүй төслийн дансад хуримтлуулан бүртгэж байна. Мөн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгээгүйтэй холбоотой дамжуулан зээлдүүлэх гэрээнд тусгагдсан 3.5 сая еврогийн зээлийн өглөгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх, зөвлөмж өгөх

3. **Худалдан авалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан бараа ажил үйлчилгээний үнийн тухайд:** Аудитын явцад тайлант хугацаанд худалдан авсан бараа, ажил үйлчилгээнээс түүвэр хийн худалдан авалтыг хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөөнд тусгагдсан эсэх, “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журамтай нийцэж буй эсэхэд горим гүйцэтгэн шалгасан. Мөн ихэнх худалдан авалтыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан үнийн дүнгээр худалдан авч байгаа байдал ажиглагдсан учир аудитын явцад хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөөнд тусгагдсан үнийг хэрхэн тооцож, үнийн судалгаа, төсвийг хэрхэн хийж байгааг хянан үзэхэд ТЗБАХ-ийн хүрээнд хийгдэх ажлуудын төлөвлөсөн хөрөнгийн дүнг ямар тооцоо, ямар үнийн судалгаа хийсний үндсэн дээр тогтоож байгаа нь тодорхойгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж буй ажил үйлчилгээний төсөвлөсөн үнийн дүнг үндэслэлтэй, бодитой тогтоох зохион байгуулалтын арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх тухайд **Зөвлөмж өгөх**

- 4. Үндсэн хөрөнгийн өртөгт бүртгэж буй зардлууд:** Компани дээр хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаатай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, хөрөнгийн элэгдэл, бичиг хэрэг, харилцаа холбоо зэрэг зардлуудыг 2040-тэй дансад хуримтлуулан бүртгэж, үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээлгэн өгөх үед хөрөнгийн өртөгт бүртгэж байна. Өөрөөр хэлбэл хөрөнгө олж бэлтгэхтэй шууд холбоогүй гарч буй зардлыг тайлант хугацааны зардлаар бус хөрөнгийн өртөгт бүртгэж байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хүрээнд дээрх ажил гүйлгээтэй холбоотой залруулгыг санал болгож **Зөвлөмж** өгсөн.

- 5. Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжилт:** Бид тус компанийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж, аудитын үр дүнгээр нийт 18 орчим зөвлөмжийг компанийн удирдлагад хүргүүлэн ажилласан ба энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянахад зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх, **Зөвлөмж** өгсөн.

- 6. Урьдчилж төлсөн төлбөр, тооцооны тухайд:** 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайланд 6,966.5 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал, тооцоо бүртгэлтэй байгаагийн 2,619.2 сая төгрөг нь өмнөх тайлант жилээс шилжиж ирсэн үлдэгдэл байна. Үүний 51.8 хувь буюу 1,433.8 сая төгрөг төгрөг нь НӨАТ-ын тооцоо, 1,228.6 сая төгрөг нь 99 айлын орон сууцны урьдчилгаа төлбөр байна. Мөн 3 байгууллагын гэрээт ажил гүйцэтгэх явцад асуудал гарч урьдчилгаа авсан боловч ажлаа гүйцэтгээгүй он дамжсан 92.4 сая төгрөг байна. НӨАТ-ын тооцоо дансны үлдэгдлийг харилцагч болон үүссэн хугацаагаар гаргуулан авч дүгнэлт судалгаа хийхэд нийт авлагын 19.0 хувь буюу 272.7 сая төгрөг нь 2014 онд үүссэн 50.7 хувь буюу 726.9 сая төгрөг нь 2015 онд үүссэн байна.

Шийдвэрлэсэн нь: 92.4 сая төгрөгийг авлагын дансад ангилан бүртгэж **Зөвлөмж** өгсөн.

- 7. Үндсэн болон туслах тоноглолын их засварын төлөвлөлт ба гүйцэтгэл:** Үндсэн тоноглолын их засварын гүйцэтгэлийн дүнг төлөвлөсөн дүнтэй харьцуулахад нийт дүнгээр хэмнэсэн байгаа ч тайлант онд төлөвлөсөн Илчит тэрэгний их засварын 830.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй, төлөвлөгөөт материалын зардлыг 873.3 сая төгрөг буюу 13.1 хувиар хэмнэсэн ч, төлөвлөсөн ажлын хөлсний зардлыг 1,343.6 сая төгрөг буюу 77.3 хувиар хэтрүүлсэн байна. Харин туслах тоноглолын хувьд төлөвлөгөөт материалын зардлыг 681.0 сая төгрөг буюу 13.8 хувиар хэмнэсэн ч, төлөвлөсөн ажлын хөлсний зардлыг 189.3 сая төгрөг буюу 40.1 хувиар хэтрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: *Зөвлөмж өгөх.*

- 8. Барилга сантехникийн их болон урсгал засварын санхүүжилтийн зориулалтын бус зарцуулалт:** Тайлант онд барилга, сантехникийн их засварт 1,149.5 сая төгрөг, урсгал засварт 283.6 сая төгрөг буюу нийт 1,433.1 сая төгрөг төсөвлөсөн байна. Гүйцэтгэлээр их засварын зардлаар төлөвлөгдсөн 1,140.7 сая төгрөгийн зардал гарсан ба үүнээс 281.0 сая төгрөгийн зардал нь барилгын урсгал засвараар зарцуулсан бол урсгал засварын зардлаар төлөвлөгдсөн 197.8 сая төгрөгийн зардал гарснаас 87.8 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөд капиталжуулсан байна. Тухайлбал, их засварын санхүүжилтээр хийгдсэн Захиргааны байрны барилгын урсгал засварын 187 дугаар гэрээ бүхий 67.3 сая төгрөгийн ажлын зардлыг урсгал засвараар бүртгэсэн бол урсгал засвараас санхүүжсэн зураг төслийн 77.0 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөд капиталжуулсан байна. Мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 49.9 сая төгрөгийн бараа материалыг урсгал засварын санхүүжилтээр, 89.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг их засварын санхүүжилтээр тус тус хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: *Зөвлөмж өгөх.*

- 9. Хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөр бүртгэх:** Бид 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг бүртгэж байх тухайд зөвлөмж хүргүүлэн ажилласан боловч энэхүү зөвлөмж хэрэгжээгүй байсан учир аудитын хүрээнд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тооцоолон санхүүгийн тайланд залруулах саналыг хүргүүлсэн. 2016 оны санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг 8,201.9 сая төгрөгөөр, тайлант хугацааны алдагдлыг 198.6 сая төгрөгөөр, өмнөх үеийн алдагдалыг 8,400.6 сая төгрөгөөр залруулан бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: НББОУС 12 “ Орлогын татвар”-ын дагуу тооцон санхүүгийн тайлан, дэлгэрэнгүй орлогын тайланд залруулан бүртгэж, *Зөвлөмж* хүргүүлсэн.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад илэрсэн материаллаг бус хэмжээний алдааг дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

- 1. Бараа материалын үлдэгдэл, үнэлгээ:** 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайланд 13,918.2 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Аудитын хүрээнд бараа материалын үлдэгдлийг өнгөрсөн жилийн эцсийн үлдэгдэлтэй харьцуулан үзэхэд 4.0 хувь буюу 502.9 сая төгрөгөөр өссөн байна. Мөн нүүрснээс бусад 7,724.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн насжилтыг гарган үзэхэд 4,501.9 сая төгрөг буюу 58.3% нь 3 ба түүнээс дээш жилийн насжилттай бараа материал байна. Үүнээс гадна 202 нэр төрлийн 209.3 сая төгрөгийн ашиглах боломжгүй бараа материал байгаа бөгөөд үүний 99% нь насжилт өндөртэй бараа материал байна.

Шийдвэрлэсэн нь:Бараа материалын нөөцийг зохистой бүрдүүлэх, хэрэгцээнээс илүү бараа материалын нөөц бий болгохгүй байх үүдээс сэлбэг хэрэгсэл, материал үнэт зүйлсийн захиалга, татан авалтын төлөвлөлтийг сайжруулах үлдэгдлийг зохистой түвшинд байлгах тухайд**Зөвлөмж** өгөх

2. **Илүү цагийн хөлс, илүү цагийн тухайд:** Жил бүр хийдэг их засварын ажлыг байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан компанийн ажилчдаар хийлгэж, илүү ажилласан цагийг тооцон хамтын гэрээний 3.5-ийн дагуу хөлсийг 2 дахин нэмэгдүүлэн олгосон. Тооцож олгосон илүү цаг нь тухайн сарын хуанлийн ажлын цагийн 30%-аас илүү байгаа бөгөөд энэ нь хамтын гэрээний 6.7.1-д заасан ажилтанг илүү цагаар сард ажиллуулах дээд хэмжээнээс хэтэрсэн төдийгүй Хөдөлмөрийн тухай хуулийн 70, 74-р заалтыг зөрчихөд хүргэж байна. Тус компани нь их засварыг өөрсдийн ажилчдаар гүйцэтгүүлэхээс гадна, гадны байгууллагаар гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж байгаа бөгөөд өөрсдийн ажилчдаар гүйцэтгүүлэх нь зардал хэмнэж байгаа гэсэн тайлбарыг өгч байгаач өнөөдөр их засварыг өөрсдөө гүйцэтгэх болон гадны байгууллагаар гүйцэтгүүлэхийн аль нь өртөг зардал хэмнэх, аль нь эргэн хариуцлага тооцох боломжтой зэрэгт хийсэн судалгаа байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Хамтын гэрээний 6.7.1 болон Хөдөлмөрийн хуулийн 70, 74-р заалтыг мөрдлөг болгон ажиллах, эдийн засгийн тооцоо судалгаа хийх талаар**Зөвлөмж** хүргүүлсэн.

3. **Ажилтны цагийн бүртгэл:**Цалингийн тооцооны хүснэгтэд тусгагдсан буюу цалин бодоход ашигласан ажилласан цагаас түүвэрлэн авч цаг бүртгэлийн ERP программаас гарч буй ажилласан цагийн мэдээлэлтэй тулган харьцуулан шалгахад хоорондоо зөрүүтэй, ERP программын мэдээллийг үндэслэн шууд ажилласан цагийг тооцох боломжгүй, цех тасаг бүрд 1 ажилтан цаг бүртгэлийг тусд нь бүртгэж, ажилласан цагийн мэдээг санхүүд бэлтгэн өгч байгаа нь ERP программын цаг бүртгэлийн программыг хангалттай хэмжээнд зөв ашиглахгүй байна гэж үзэхээр байна.ERP программаас гарч буй мэдээллээс харахад нэвтэрч орсноос 3 өдрийн дараа гарсан, зарим өдөр орсон боловч гарсан мэдээлэл байхгүй аль эсвэл эсрэгээр нэвтэрч орсон мэдээлэлгүйгээр зөвхөн гарсан мэдээлэл бүртгэгдсэн зэрэг шууд боловсруулалт хийх боломжгүй байдалтай байсан.

Шийдвэрлэсэн нь:**Зөвлөмж** хүргүүлсэн.

4. **Гэрээт ажилчид:** 2016 онд хөлсөөр ажиллах гэрээ 113-н хүнтэй байгуулан 1,046.0 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна. Гэрээт ажилчидтай байгуулсан гэрээг хугацаагаар ангилан авч үзвэл 3 ажилтантай 2-3 жилээр, 4 ажилтантай 1,5-2 жилээр, 4 ажилтантай 1-1,5 жилээр тус тус гэрээ байгуулсан байна. Компанийн 2016 оны батлагдсан орон тоо 1492, гүйцэтгэлээр 1477 байсан ба дээрх гэрээт ажилчид батлагдсан орон тоонд ороогүй бөгөөд эдгээр ажилчдад олгосон цалин хөлсийг их засварт бүртгэж байна.

Шийдвэрлэсэн нь: **Зөвлөмж** хүргүүлсэн.

5. **Ажлаас халагдсаны тэтгэмж:** Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1-р заалтын дагуу ажлаас халагдсаны тэтгэмж олгохдоо ихэнх ажилтанд 3 сарын, зарим нэр бүхий цөөн тооны ажилтанд 6, 12 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж тооцож олгосон байгаа бөгөөд энэ нь ямар үндэслэлээр 3,6,12 сарын тэтгэмж олгож байгаа нь тодорхойгүй байна. Мөн 2016 оны 01 дүгээр сард Захиргаа хүний нөөцийн албаны менежер, 2016 оны 12 дугаар сард Эдийн засаг санхүүгийн албаны Санхүүгийн менежерыг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний 12.10-р заалт (ажлын байр, орон тоо хасагдсан)-ыг үндэслэн ажлаас чөлөөлж 12-24 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгосон. Гэсэн хэдий ч компанийн 2016 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээнээс харахад Захиргаа хүний нөөцийн алба 12 орон тооны ажилтан төлөвлөснөөс гүйцэтгэлээр 13 ажилтан ажилласан, Эдийн засаг санхүүгийн алба 18 орон тооны ажилтан төлөвлөснөөс гүйцэтгэлээр 18 ажилтан ажилласан байгаа нь орон тооны цомхотгол хийгээгүй нь харагдаж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

6. **Татварын эрсдэл:** “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу ажилтанд олгосон сувиллын хөнгөлөлт, ажлаас чөлөөлөгдсөний тэтгэмжээс ХХОАТ суутгалгүй, нийт дүнгээр олгосон байна. Мөн актахаар шийдвэр хүлээж буй ашиглалтгүй хөрөнгөд байгуулсан 37.6 сая төгрөгийн элэгдлийг татвар ноогдох орлогоос хасагдах зардлаар тооцож байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

7. **Эрчим зоогийн газрын үйл ажиллагааны талаар:** Эрчим зоогийн газар нь 45 хүний бүрэлдэхүүнтэй өдрийн 2 ээлжээр ажиллаж, ажилчдад үйлчилдэг. 2016 онд Эрчим зоогийн газар нь 1,091.8 сая төгрөгийн орлого олж, 1,038.1 сая төгрөгийн материалын зардал, 1,268.4 сая төгрөгийн цалингийн зардал, 164.9 сая төгрөгийн НДШ-ийн зардал, 57.2 сая төгрөгийн гэрэл цахилгааны зардал тус тус зарцуулсан байна. Компани нь материалын зардлаас бусад зардлыг өртөгт тайлагнаж зоогийн газрын ашиг алдагдлыг зөвхөн материалын зардлаар тооцон гаргаж байна. НББОУС 18 “Орлого”-ын дагуу орлого, өртөг уялдах зарчмаар 2016 оны Эрчим зоогийн газрын үйл ажиллагаанаас олох ашиг алдагдлыг тооцон үзэхэд 1,436.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

8. **Дэлгүүрийн бараа материалын худалдан авалт:** 2016 онд дэлгүүрт 361.5 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Дэлгүүрийн худалдан авсан бараа материалыг нэр төрлөөр нь өссөн дүнгээр нэгтгэн харахад 100.6 сая төгрөгийн тамхи, 54.2 сая төгрөгийн ус, ундаа жүүс нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу худалдан авалт хийхээр байгаач энэхүү хуулийг мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хөргөх цамхаг-4 - НББОУС-36 “Хөрөнгийн үнэ цэнийн бууралт”-9-д аж ахуйн нэгж нь хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлэх ёстой бөгөөд ийм ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолох ёстой гэж заасан. Гэвч компанийн үндсэн хөрөнгийн дансад 2012 оны 12 дугаар сарын 31-нд орлогоор бүртгэсэн 5,668.6 сая төгрөгийн анхны өртөгтэй “**Хөргөх цамхаг-4**” хөрөнгө ашиглалтанд ороод удаагүй үйл ажиллагааны доголдол үүсч улмаар гүйцэтгэгч тодорхой засвар хийсэн хэдий ч үйл ажиллагаа доголдсон хэвээр байгаа төдийгүй техникийн болон улсын комисс хүлээн аваагүй. 2014 оноос өвлийн улиралд үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон бөгөөд 2015 оны 11 дүгээр сараас элэгдэл байгуулахыг зогсоосон боловч энэхүү хөрөнгөнд үнэ цэнийн бууралт тооцож бүртгээгүй байна.

Хөрөнгийг элэгдүүлэх бодлого горим - Тус компани өмнөх тайлант жилүүдэд төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох тухай Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор баталсан журмыг, 2015 оноос Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 1/250 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох” журмыг баримтлан үндсэн хөрөнгийг элэгдүүлэх ёстой боловч Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифтай уялдуулан Төрийн өмчийн хорооноос баталсан компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүнд тохируулж үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцон, бүртгэж байгаатай холбоотой санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдэл өртөг илүү, элэгдлийн зардал, хуримтлагдсан элэгдэл дутуу илэрхийлэгдэхэд хүрч байна.

Хөрөнгийн үнэлгээ-Тус компанийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг 2008 онд “Итгэлт аудит” ХХК хийснээс хойш үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй, 2012 онд “Үндэсний реалти” ХХК хөрөнгийн дахин үнэлгээ хийх гэрээ байгуулан ажилласан боловч хөрөнгийн бүртгэлийг ERP системд шилжүүлж тоног төхөөрөмжийн ангиллыг шинээр хийж хөрөнгийг задалж бүртгэх болсонтой холбоотойгоор тоног төхөөрөмжийн үнэлгээг дээрх ангиллаар хийх болсон бахөрөнгийн үнэ цэнийн бууралтын тест хийх болсонтой холбоотойгоор нэмэлт судалгаа, хөрөнгө зарцуулах шаардлагатай болж хойшлуулсаар 2016 онд 2012 оны хөрөнгийн үлдэгдэлд хийсэн үнэлгээний тайланг өгснөөр энэхүү хөрөнгийн үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах боломжгүй болсон байна. Өөрөөр хэлбэл компанийн үндсэн хөрөнгийн дүнд 2008 оноос хойш үнэлгээ хийгдээгүй, хөрөнгө санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй байна.

Төсвийн зардлыг хэмнэх-Монгол Улсын Улсын Их Хурлаас 2016 оны 9 дүгээр сарын 09-ны өдөр баталсан Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр гаргасан 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хянан үзэхэд,

- Сарын үр дүнгийн шагналд 9 дүгээр сард 484,5 сая төгрөг 10 дугаар сард 629,7 сая төгрөг, 11 дүгээр сард сард 616,2 сая төгрөг, 12 дугаар сард 731.8 сая төгрөг

тус тус олгосон. Бусад шагнал, урамшуулалд 9 дүгээр сард 4.7 сая төгрөг, 10 дугаар сард 2.6 сая төгрөг, 11 дүгээр сард 3.6 сая төгрөг, 12-р сард 66.2 сая төгрөг тус тус олгосон байгаа нь тогтоолын 2.а <<...цалин хөлс, урсгал зардлыг бууруулах...>>

- Дээрх тогтоол гарсанаас хойш 39.8 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байгаа нь тогтоолын 2.в.3-т <<тавилга шинээр худалдан авахгүй байх>>
- Шинэ жилийн арга хэмжээнд 56.4 сая төгрөг зарцуулсан нь 2.в.5-д <<төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх>> гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Мөн “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-нд тусгаагүй 61.8 сая төгрөгийн Салбарын тэргүүний тэмдэгийн мөнгийг олгосон байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2016 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн хэсэгт тусгасан болон залруулаагүй алдааг дараагийн тайлангийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй.

Дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгэх:Компани нь 2008 оны жилийн эцсээр үндсэн хөрөнгийн дүнд дахин үнэлгээ хийлгэж дахин үнэлгээний үр дүнгээр үндсэн хөрөнгийн үнэ өсч, дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дахин үнэлгээний нэмэгдлийг хүлээн зөвшөөрч бүртгэх талаар тодорхой тусгагдаагүй байгаа бөгөөд компани дахин үнэлгээний хэрэгжилтийг тухайн хөрөнгийг данснаас хасах үедээ хүлээн зөвшөөрч бүртгэж ирсэн. НББОУС-16 “Үндсэн хөрөнгө”-ийн 41-д Өмчийн дүнд багтсан дахин үнэлгээний нэмэгдлийг хөрөнгийг данснаас хасах үед хуримтлагдсан ашиг, алдагдалд шилжүүлж болох бөгөөд аж ахуйн нэгж хөрөнгийг ашиглаж байх үедээ дахин үнэлгээний нэмэгдлийн зарим хэсгийг хэрэгжүүлж болохоор заасан. Иймээс дахин үнэлгээний хэрэгжилтийг хөрөнгийг ашиглаж байх үедээ хүлээн зөвшөөрөх аргаар тооцоолон 2016 оны санхүүгийн тайланд тусгахаар ажилласан боловч тооцооллыг хөрөнгө тус бүрээр гаргах учирцаг хугацааны хувьд амжаагүй болно. Энэхүү дахин үнэлгээний нөөцийн зарим хэсгийн хэрэгжилтийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт **24,152.68** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж эдгээр алдаа, зөрчил бүрт зөвлөмж өгч, **13,862.6** сая төгрөгөөр санхүүгийн тайланг залруулсан.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2015 оны санхүүгийн тайланд манай компаниаудит хийж, аудитын үр дүнгээр 18-н зөвлөмж өгсөн ба энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянахад 41.6 хувийн биелэлттэй байна.

17. Аудитынхязгаарлалттай дүгнэлтийн санал

Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 16 “Үндсэн хөрөнгө”-тэй нийцэхгүй байгаа ба үүнээс үүсэх үр нөлөө нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөлтэй байна.

Хязгаарлалттай дүгнэлт

Дээр дурьдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эстооцвол “**Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц**” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК- ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах
хаягаар харилцана уу:

Газрын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512, 262885
Цахим хаяг: sambuunyamyu@audit.mn

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Монгол Улс, Чингэлтэй дүүрэг Бага
тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: www.mnao.mn



Гроут финанс аудит ХХК

Гүйцэтгэх захирал
Б.Бямба
Аудитын менежер: Э.Мөнхтогтох
Аудитор: Т.Ариунжаргал
Утас: 99094391, 91913664

Цахим хаяг:
info@growthfinance.mn

Гроут финанс Аудит ХХК-ийн хаяг:
Улаанбаатар 16030, Баянгол дүүрэг, 3
дугаар хороо Үйлдвэрийн бүс,
Энгельсийн гудамж 11-191 тоот

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол 1: Асуудал 1-7

Тэргүүлэх ач холбогдол 2: Асуудал 8-12

Тэргүүлэх ач холбогдол 3: Асуудал 13-17

1. Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн бүртгэл	Тэргүүлэх ач холбогдол 1
<u>Бодит байдал</u> “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-ний 12.1-ийн дагуу << тус компанид сүүлийн 10 жил тасралтгүй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарахаар ажлаас чөлөөлөгдсөн хүнд эрчим хүчний салбарт ажилласан бүх жилийг оролцуулан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг >> олгож байна. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ойролцоогоор 727.7 сая төгрөгийн нэг удаагийн ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг олгох шийдвэр гарсны дагуу тайлант хугацааны зардлаар бүртгэж тайлагнасан байгаа нь НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр тэтгэмж”-тэй нийцэхгүй байна. Аудитын хүрээнд 2015 болон 2016 оны байдлаар ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн өр төлбөрийг стандартын дагуу тооцоолон 4,784.8 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгахаар залруулга хүргүүлсэн.	
<u>Эрсдэл</u> Тайлант хугацааны зардал, нөөц өр төлбөр зөрүүтэй тайлагнагдах эрсдэлтэй.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Хамтын гэрээний дагуу олгож буй нэг удаагийн ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр тэтгэмж”-д заасны дагуу бүртгэх Нэг удаагийн ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, өр төлбөрийг бодох, тооцох аргачлал журмыг НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр тэтгэмж”-тэй нийцүүлэн боловсруулж мөрдөх буюу аудитын үр дүнгээр өгсөн залруулгыг санхүүгийн тайланд тусгах	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Хамтын гэрээний дагуу олгож буй нэг удаагийн ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр тэтгэмж”-д заасны дагуу бүртгэнэ. Нэг удаагийн ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, өр төлбөрийг бодох, тооцох аргачлал журмыг НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр тэтгэмж”-тэй нийцүүлэн боловсруулан мөрдөхөөс гадна аудитын үр дүнгээр өгсөн залруулгыг санхүүгийн тайланд тусгасан.	

2. Ашиглаж эхэлсэн боловч хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй хөрөнгө ба түүнтэй холбоотой зээлийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт	Тэргүүлэх ач холбогдол 1
<u>Бодит байдал</u> 2010 оноос хойш тус компанийн дотоод циклийн усыг “Эсрэг осмос + цахилгаан деионизаци”-ийн технологиор бэлтгэх төслийн судалгаа явагдаж улмаар Эрчим хүчний үр ашиг II төслийн хүрээнд 3.75 сая еврогоор санхүүжүүлэх Засгийн газрын шийдвэр гарсан байна. Төслийн тендерийг 2013 оны 3 дугаар сард олон улсад нээлттэй зарлаж БНХАУ-ын Нарн Футонг компани гүйцэтгэгчээр шалгарч 2013 оны 8 дугаар сарын 16-нд гэрээ байгуулан төслийн угсралт суурилуулалтын ажил эхлэн 2014 оны 11 дүгээр сарын 19-нд албан ёсоор хүлээн авч, 2016 оны 10 дугаар сард Техникийн комиссын акт гарсан ба Улсын комисст хүлээлгэн өгөөгүй гэсэн шалтгаанаар өнөөдрийг хүртэл энэхүү тоноглолыг үндсэн хөрөнгөд орлого аваагүй дуусаагүй төслийн дансад хуримтлуулан бүртгэж байна. Мөн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгээгүйтэй холбоотой дамжуулан зээлдүүлэх гэрээнд тусгагдсан 3.5 сая еврогийн зээлийн өглөгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй. Тухайн тоноглолыг ашиглаад эхэлсэн хэдий ч хөрөнгөөр бүртгээгүй байгаагаас тоноглолд хийсэн засварын зардал болох 148.0 сая төгрөгийг тайлант онд зардлаар бус дуусаагүй төслийн дансад бүртгэснийг завсарын хугацааны аудитаар залруулан бүртгэсэн. Мөн ажлын хэсэгтэй холбоотой гарч буй цалин, бусад зардлыг дуусаагүй төслийн дансад бүртгэснийг залруулан тайлант хугацааны зардлаар бүртгэсэн.	
<u>Эрсдэл</u> Хөрөнгийг ашиглаж орлого олж эхэлсэн ч зардал хүлээн зөвшөөрөөгүй нь орлого, зардал уялдах зарчим алдагдаж хөрөнгийн өгөөж зөрүүтэй тооцогдох төдийгүй Иж, Үз, ЭҮ батламж мэдэгдлийг хангахгүй байна.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-д зааснаар аж ахуйн нэгж ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн эдийн үр өгөөж хүртэх магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой байх нөхцөлд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу өөрөөр хэлбэл, түүнийг удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангасан үеэс эхлэн элэгдэл тооцно гэж тус тус заасан. Хөрөнгийг Техникийн комисс, Улсын комисст хүлээлгэн өгөөгүй гэдэг үндэслэлээр үндсэн хөрөнгийн дансад бүртгэхгүй байгаа нь НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-тэй нийцэхгүй байгаа төдийгүй хөрөнгө ашиглагдаж, элэгдэж хорогдож байгааг хөрөнгийг элэгдүүлээгүй байгаа зэргийг удирдлагын зүгээс анхаарч Улсын комисст хүлээлгэн өгөх талаар зохих арга хэмжээг авах нь зүйтэй. Цаашид хөрөнгийг цаг тухайд нь Техникийн комисс, Улсын комисст хүлээлгэн өгч байх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.	

Үйлчлүүлэгчийн хариу

Тус компанид хэрэгжсэн төслийн хөрөнгийг техникийн комисс, улсын комисст хүлээлгэн өгөлгүй үндсэн хөрөнгөнд бүртгэсэний улмаас шалгалт хийсэн мэргэжлийн байгууллагууд акт, албан шаардлага тавьж байна. Иймээс Монгол Улсын хууль тогтоомж, НББОУСтандарт хоорондоо зөрчилдөж байгаа тул холбогдох эрх бүхий байгууллагуудаар хоорондын уялдаа холбоог хангуулсан шийдвэр гаргуулахад анхааран ажиллах болно.

3. Худалдан авалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан бараа ажил үйлчилгээний үнийн тухайд

Тэргүүлэх ач холбогдол 1

Бодит байдал

Аудитын явцад тайлант хугацаанд худалдан авсан бараа, ажил үйлчилгээнээс түүвэр хийн худалдан авалтыг хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөөнд тусгагдсан эсэх, “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журамтай нийцэж буй эсэхэд горим гүйцэтгэн шалгасан. Мөн ихэнх худалдан авалтыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан үнийн дүнгээр худалдан авч байгаа байдал ажиглагдсан учир аудитын явцад хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөөнд тусгагдсан үнийг хэрхэн тооцож, үнийн судалгаа, төсвийг хэрхэн хийж байгаа нь тодорхойгүй байна. Тухайлбал, Тайлант онд ТЗБАХ-ийн хүрээнд 17 ажлыг хийхээр төлөвлөсөн байгаа ба эдгээр ажлын 88 хувь буюу 15 ажлын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөсөн хөрөнгийн төсөв, тооцоо байхгүй байна. Өөрөөр хэлбэл ТЗБАХ-ийн хүрээнд хийгдэх ажлуудын төлөвлөсөн хөрөнгийн дүнг ямар тооцоо, ямар үнийн судалгаа хийсний үндсэн дээр тогтоож байгаа нь тодорхойгүй байна.

Эрсдэл

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөвлөсөн хөрөнгийн үнийн дүнг үндэслэлтэй тооцоогүйгээс хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй.

Санал болгосон зөвлөмж

Удирдлагын зүгээс хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж буй ажил үйлчилгээний төсөвлөсөн үнийн дүнг үндэслэлтэй, бодитой тогтоох зохион байгуулалтын арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

ТЗБАХ-ын төлөвлөгөөг хийхдээ тухайн санал оруулж байгаа нэгжийн удирдлага байгууллагын удирдлагуудтай хэлэлцэн төлөвлөгөөнд оруулдаг. 2017 оны ТЗБАХ-ны төлөвлөгөөг боловсруулахдаа үр ашиг, өгөөжийн тооцоог үндэслэн төлөвлөж байх зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна.

4. Үндсэн хөрөнгийн өртөгт бүртгэж буй зардлууд	Тэргүүлэх ач холбогдол 1
<u>Бодит байдал</u> Компани дээр хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаатай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, хөрөнгийн элэгдэл, бичиг хэрэг, харилцаа холбоо зэрэг зардлуудыг 2040-тэй дансад хуримтлуулан бүртгэж, үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээлгэн өгөх үед хөрөнгийн өртөгт бүртгэж байна. Өөрөөр хэлбэл хөрөнгө олж бэлтгэхтэй шууд холбоогүй гарч буй зардлыг тайлант хугацааны зардлаар бус хөрөнгийн өртөгт бүртгэж байна.	
<u>Эрсдэл</u> Үндсэн хөрөнгийн анхны өртгийн хувьд Үз, Иж, Ү батламж хангагдахгүй.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 16, 17 дугаар заалтад заасны дагуу хөрөнгийг худалдан авах, олж бэлтгэх, удирдлагын зорилгоор ашиглахад бэлэн болгохтой холбоотой гарч буй шууд зардалд төслийн нэгжтэй холбоотой зардал хамаарахгүй юм. Иймээс хөрөнгө олж бэлтгэхтэй шууд хамааралгүй гарч буй аливаа зардлыг хөрөнгийн өртөгт бус тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Компани дээр хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаатай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, хөрөнгийн элэгдэл, бичиг хэрэг, харилцаа холбоо зэрэг зардлуудыг 2040-тэй дансад хуримтлуулан бүртгэж, үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээлгэн өгөх үед хөрөнгийн өртөгт бүртгэж байсныг НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 16, 17 дугаар заалтад заасны дагуу хөрөнгийн өртөгт бус тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч тайланд залруулан бүртгэж зөвлөмжийг хэрэгжүүлсэн.	

5. Бараа материалын үлдэгдэл, үнэлгээ	Тэргүүлэх ач холбогдол 1
<u>Бодит байдал</u> 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайланд 13,918.2 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Аудитын хүрээнд бараа материалын үлдэгдлийг өнгөрсөн жилийн эцсийн үлдэгдэлтэй харьцуулан үзэхэд 4 хувь буюу 502.9 сая төгрөгөөр өссөн байна. Мөн нүүрснээс бусад 7,724.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн насжилтыг гаргаж үзэхэд 4,501.9 сая төгрөг буюу 58.3% нь 3 ба түүнээс дээш жилийн насжилттай бараа материал байна. Үүнээс гадна 202 нэр төрлийн 209.3 сая төгрөгийн ашиглах боломжгүй бараа материал байгаа бөгөөд үүний 99% нь насжилт өндөртэй бараа материал байна.	
<u>Эрсдэл</u> Бараа материалын нөөцийн зохистой харьцаа алдагдаж хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах төдийгүй санхүүгийн тайланд бараа материал Үз, Үн байна гэсэн батламж мэдэгдэл хангагдахгүйд хүрнэ.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Бараа материалын нөөцийг зохистой бүрдүүлэх, хэрэгцээнээс илүү бараа материалын нөөц бий болгохгүй байх үүдээс сэлбэг хэрэгсэл, материал үнэт зүйлсийн захиалга, татан авалтын төлөвлөлтийг сайжруулах үлдэгдлийг зохистой түвшинд байлгахад анхаарах шаардлагатай. Мөн тайлант жилийн эцсээр хөдөлгөөн огт гараагүй, хөдөлгөөн удаантай сэлбэг хэрэгсэл, материалын үлдэгдэлд удирдлагын зүгээс дүн шинжилгээ хийж хөдөлгөөн гараагүй ашиглахгүй удсан сэлбэг хэрэгслийн шалтгааныг тогтоож худалдан борлуулах, хэрэгцээтэй салбар нэгжүүдэд шилжүүлэх, хэрэгцээ шаардлага хангахгүй бараа материалыг актлах зэргээр эргэлтэнд оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> 2016 оны жилийн эцсийн бараа материалын үлдэгдэлд насжилтын судалгаа хийхэд 3099,2 сая төгрөг нь 1 жил, 853,0 сая төгрөг нь 1-3 жил, 2785,5 сая төгрөг нь 3-5 жил, 1690,7 сая төгрөг нь 5-аас дээш жил болж байгаа сэлбэг хэрэгсэл, материал байна. Дээрх насжилтын судалгааны дагуу хөдөлгөөн огт гараагүй, хөдөлгөөн удаантай сэлбэг хэрэгсэл, материалын үлдэгдэлд удирдлагын зүгээс дүн шинжилгээ хийж хөдөлгөөн гараагүй ашиглахгүй удсан сэлбэг хэрэгслийн шалтгааныг тогтоож худалдан борлуулах хэрэгцээтэй салбар нэгжүүдэд шилжүүлэх, хэрэгцээ шаардлага хангахгүй бараа материалыг актлах хүсэлтийг холбогдох байгууллагад гарган зохих зөвшөөрлийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллах болно.	

6. Хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөр бүртгэх	Тэргүүлэх ач холбогдол 1
<u>Бодит байдал</u> Бид 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг бүртгэж байх тухайд зөвлөмж хүргүүлэн ажилласан боловч энэхүү зөвлөмж хэрэгжээгүй байсан учир аудитын хүрээнд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тооцоолон санхүүгийн тайланд залруулах саналыг хүргүүлсэн. 2016 оны санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг 8,201.9 сая төгрөгөөр, тайлант хугацааны алдагдлыг 198.6 сая төгрөгөөр, өмнөх үеийн алдагдалыг 8,400.6 сая төгрөгөөр залруулан бүртгэсэн.	
<u>Эрсдэл</u> Компанийн тайлант жилийн цэвэр ашиг алдагдал зөрүүтэй илэрхийлэгдэх төдийгүй Үз, ТИ батламж мэдэгдлийг хангахгүй байна.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Аудитын үр дүнгээр хийсэн залруулгыг санхүүгийн тайланд тусгах	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> НББОУС-12-оор бүртгэх тооцооллыг хийдэг боловч компанийн үнэ тарифыг төрөөс зохицуулдаг болон ирээдүйд компани ашигтай ажиллах асуудал тодорхой бус байдагтай холбоотой тухайн бичилтыг хийлгүй ирсэн. Цаашид тарифын зохицуулалтыг ЭХЗХорооноос шат дараалалтай хийж байгаатай холбоотой ирэх жилүүдийн орлого, зардлын судалгаа тооцоо хийж бичилтыг хийхэд анхаарч ажиллах. Аудитын үр дүнгээр 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан.	

7. Илүү цагийн хөлс, илүү цагийн тухайд	Тэргүүлэх ач холбогдол 1
<u>Бодит байдал</u> Жил бүр хийдэг их засварын ажлыг байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан компанийн ажилчдаар хийлгэж, илүү ажилласан цагийг тооцон хамтын гэрээний 3.5-ийн дагуу хөлсийг 2 дахин нэмэгдүүлэн олгосон. Тооцож олгосон илүү цаг нь тухайн сарын хуанлийн ажлын цагийн 30%-иас илүү байгаа бөгөөд энэ нь хамтын гэрээний 6.7.1-д заасан ажилтанг илүү цагаар сард ажиллуулах дээд хэмжээнээс хэтэрсэн төдийгүй Хөдөлмөрийн тухай хуулийн 70, 74-р заалтыг зөрчихөд хүргэж байна. Тус компани нь их засварыг өөрсдийн ажилчдаар гүйцэтгүүлэхээс гадна, гадны байгууллагаар гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж байгаа бөгөөд өөрсдийн ажилчдаар гүйцэтгүүлэх нь зардал хэмнэж байгаа гэсэн тайлбарыг өгч байгаач өнөөдөр их засварыг өөрсдөө гүйцэтгэх болон гадны байгууллагаар гүйцэтгүүлэхийн аль нь өртөг зардал хэмнэх, аль нь эргэн хариуцлага тооцох боломжтой зэрэгт хийсэн судалгаа байхгүй байна.	
<u>Эрсдэл</u> Ажилчдыг илүү цагаар хавтгайруулан ажиллуулах нь хөдөлмөр, аюулгүй ажиллагаа зөрчигдөх эрсдэлтэй.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Компанийн их засварын ажлыг өөрсдийн ажилчдаар хийлгэх, гадны байгууллагаар хийлгэж байгаагийн аль нь эдийн засгийн ашигтай байгаад тооцоо судалгаа хийх Хамтын гэрээний 6.7.1 болон Хөдөлмөрийн хуулийн 70, 74-р заалтыг мөрдлөг болгон ажиллах	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Хамтын гэрээний 6.7.1 болон Хөдөлмөрийн хуулийн 70, 74-р заалтыг мөрдлөг болгон анхаарч ажиллах болно. Компанийн их засварын ажлыг өөрсдийн ажилчдаар хийлгэх, гадны байгууллагаар хийлгэж байгаагийн аль нь эдийн засгийн ашигтай талаар тооцоо судалгаа хийн ажиллахын зэрэгцээ жилийн болон сарын үр дүнгийн шагнал олгох, илүү цагийн хөлс олгох журамыг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах болно.	

8. Үндсэн болон туслах тоноглолын их засварын төлөвлөлт ба гүйцэтгэл	Тэргүүлэх ач холбогдол 2
<u>Бодит байдал</u> Тайлант онд үндсэн тоноглолын их засварын материалын зардалд 6,687.6 сая төгрөг, ажлын хөлсөнд 2,568.8 сая төгрөг буюу нийт 9,256.4 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,811.3 сая төгрөгийн материал, 3,082.4 сая төгрөгийн ажлын хөлсний зардал гарч нийт дүнгээрээ 8,893.7 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн байна. Хэдийгээр хэмнэсэн байгаач тайлант онд төлөвлөсөн Илчит тэрэгний ихзасварын 830.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөт материалын зардлыг 873.3 сая төгрөг буюу 13.1 хувиар хэмнэсэн ч, төлөвлөсөн ажлын хөлсний зардлыг 1,343.6 сая төгрөг буюу 77.3 хувиар хэтрүүлсэн байна. Үүнд Илчит тэрэгний төлөвлөсөн боловч гүйцэтгээгүй ажлын хөлсний зардлыг хасч тооцсон. Харин туслах тоноглолын их засварын материалын зардалд 4,927.6 сая төгрөг, ажлын хөлсөнд 472.4 сая төгрөг буюу нийт 5,400.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,246.6 сая төгрөгийн материал, 661.7 сая төгрөгийн ажлын хөлсний зардал гарч нийт дүнгээрээ 4,908.3 сая төгрөгийн их засварын ажил хийгдэж 491.7 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөт материалын зардлыг 681.0 сая төгрөг буюу 13.8 хувиар хэмнэсэн ч, төлөвлөсөн ажлын хөлсний зардлыг 189.3 сая төгрөг буюу 40.1 хувиар хэтрүүлсэн байна. Нэг талаас үндсэн болон туслах тоноглолын их засварын төлөвлөлтөнд тусгасан ажлын хөлсний зардлын хэтрэлт 1,532.9 сая төгрөг, нөгөө талаас нийт дүнгээр тайлант онд дээрх их засварын зардал 854.4 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан нь материалын зардлыг 1,554.3 сая төгрөгөөр илүү төлөвлөснийг харуулж байна.	
<u>Эрсдэл</u> Үндсэн болон туслах тоноглолын их засварын төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөсөн зардлын үнийн дүнг үндэслэлтэй тооцоогүйгээс хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, цаашлаад үндсэн хөрөнгө үнэн зөв, бодитой илэрхийлэгдэхгүй байх эрсдэлтэй.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Удирдлагын зүгээс үндсэн болон туслах тоноглолын их засварын төлөвлөгөөнд тусгагдаж буй материал болон ажлын хөлсний үнийн дүнг үндэслэлтэй эсэхэд хяналт тавьж, гүйцэтгэлтэй харьцуулан хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тодорхойлон, цаашид бодитой тогтоох ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Цаашид үндсэн болон туслах тоноглолын их засварын төлөвлөгөөг боловсруулахдаа материал болон ажлын хөлсний үнийн дүнг тооцоо судалгаа, үндэслэлтэй тооцож, материал үнийн судалгааны эдийн засагчаар хянуулан баталгаажуулж, гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бодитой тодорхойлон ажиллах болно.	

9. Барилга сантехникийн их болон урсгал засварын санхүүжилтийн зориулалтын бус зарцуулалт	Тэргүүлэх ач холбогдол 2
<u>Бодит байдал</u> Тайлант онд барилга, сантехникийн их засварт 1,149.5 сая төгрөг, урсгал засварт 283.6 сая төгрөг буюу нийт 1,433.1 сая төгрөг төсөвлөсөн байна. Гүйцэтгэлээр их засварын зардлаар төлөвлөгдсөн 1,140.7 сая төгрөгийн зардал гарсан ба үүнээс 281.0 сая төгрөгийн зардал нь барилгын урсгал засвараар зарцуулсан бол урсгал засварын зардлаар төлөвлөгдсөн 197.8 сая төгрөгийн зардал гарснаас 87.8 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөд капиталжуулсан байна. Тухайлбал, их засварын санхүүжилтээр хийгдсэн Захиргааны байрны барилгын урсгал засварын 187 тоот гэрээ бүхий 67.3 сая төгрөгийн ажлын зардлыг урсгал засвараар бүртгэсэн бол урсгал засвараас санхүүжсэн зураг төслийн 77.0 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөд капиталжуулсан байна. Мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 49.9 сая төгрөгийн бараа материалыг урсгал засварын санхүүжилтээр, 89.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг их засварын санхүүжилтээр тус тус хийсэн байна.	
<u>Эрсдэл</u> Хөрөнгийг зориулалтын бус санхүүжилтээр хийх нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төлөвлөгөөний биелэлт зөрүүтэй илэрхийлэгдэх	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Иймд барилга сантехникийн урсгал болон их засварын төлөвлөгөөг бодитой, үнэн зөв хийж, төлөвлөсөн зардлаа хэтрүүлэхгүй, төлөвлөгөөний дагуу зарцуулах, түүний хэрэгжилтэнд удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллах. Мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийгүй байх	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Барилга сантехникийн урсгал болон их засварын ажлын төлөвлөгөөний дагуу зохиож буй төсвийг бодитой, үнэн зөв, тооцоо судалгаатай хийж, гүйцэтгэлийг НББОУС-ын дагуу бүртгэж, засварын ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж, дүгнэлт хийж ажиллах болно.	

10. Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжилт	Тэргүүлэх ач холбогдол 2
<u>Бодит байдал</u> Бид тус компанийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж, аудитын үр дүнгээр нийт 18 орчим зөвлөмжийг компанийн удирдлагад хүргүүлэн ажилласан ба энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянахад дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд ✚ Хөргөх цамхаг -4: НББОУС-16 “Үндсэн хөрөнгө”, НББОУС-36 “Хөрөнгийн үнэ цэнийн бууралт”-ын заалтуудыг хэрэгжүүлэх. Үүний тулд хөрөнгөнд гарсан эвдрэл гэмтлийг мэргэжлийн байгуулагаар тогтоолгож, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн дагуу шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хандан хөрөнгийн асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх ✚ Тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаж болохуйцаар тооллогын ажлыг зохион байгуулах, санхүүгийн тайланд үр дүнг тусгах ✚ Компани нь байгаль орчныг нөхөн сэргээх төсөв, төлөвлөгөө боловсруулан түүний дагуу тогтоогдсон нөхөн сэргээх зардлыг үнэсэн санг ашиглахаар төлөвлөсөн хугацаанд хуваарилж нөөц байгуулах шаардлагатай ✚ НӨАТ-ын хуулийн дагуу Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчтэй байгуулсан гэрээнд НӨАТ болон бусад татварыг тусгаж хуулийн дагуу аливаа татварыг суутган төлөх ✚ Бүртгэлд тусгаагүй хөрөнгийн үнэлгээг тогтоон хөрөнгийн дансад зохих ангилалд бүртгэх ✚ Эдийн засаг, санхүү, судалгаа хөгжлийн алба хоорондоо уялдаатай ажиллаж төсөл эхлэхээс эхлээд хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг сайн хийж төслийн үр өгөөжийг тооцон гаргаж байх	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, татварын эрсдэлтэй холбоотой аудитын өгч буй зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад удирдлагын зүгээс анхаарч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Энэ онд зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган батлуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах болно. Мөн компанийн зүгээс шийдвэрлэх боломжгүй төрөөс зохицуулалттай үнэ тарифыг боломжит хэмжээнд хүртэл батлуулах, НБББББ-т холбогдох өөрчлөлтүүдийг хийх зэрэг ажлуудыг тодорхой үе шаттайгаар хийх болно.	

11. Урьдчилж төлсөн зардал, тооцооны дансны тухай	Тэргүүлэх ач холбогдол 2
<u>Бодит байдал</u> 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайланд 6,966.5 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал, тооцоо бүртгэлтэй байгаагийн 2,619.2 сая төгрөг нь өмнөх тайлант жилээс шилжиж ирсэн үлдэгдэлбайна. Үүний 51.8 хувь буюу 1,433.8 сая төгрөг төгрөг нь НӨАТ-ын тооцоо, 1,228.6 сая төгрөг нь 99 айлын орон сууцны урьдчилгаа төлбөр байна. Мөн 3 байгууллагын гэрээт ажил гүйцэтгэх явцад асуудал гарч урьдчилгаа авсан боловч ажлаа гүйцэтгээгүй он дамжсан 92.4 сая төгрөг байна. НӨАТ-ын тооцоо дансны үлдэгдлийг харилцагч болон үүссэн хугацаагаар гаргуулан авч дүгнэлт судалгаа хийхэд нийт авлагын 19.0 хувь буюу 272.7 сая төгрөг нь 2014 онд үүссэн, 50.7 хувь буюу 726.9 сая төгрөг нь 2015 онд үүссэн байна. Энэхүү үүсээд удсан НӨАТ-ын тооцооны авлагыг харилцагчаар нь судлан үзэхэд гэрээний төлбөрийг тус компани төлөөд дууссан, ажил үйлчилгээ нь хэрэгжсэн байгаагч НӨАТ-ын падаанаа аваагүйгээс худалдан авалтын НӨАТ-ыг ашиглаж чадаагүй байна. Аудитын хүрээнд урьдчилгаа авсан боловч ажлаа гүйцэтгээгүй он дамжсан 92.4 сая төгрөгийг авлагын дансад ангилан бүртгэсэн.	
<u>Эрсдэл</u> Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг зөрүүтэй мэдээллээр хангах, НӨАТ-ын авч чадаагүй тооцооны дүнгээр компанийн зардал өсч ашиг буурах эрсдэлтэй байна.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Урьдчилгаа авсан боловч ажлаа гүйцэтгээгүй он дамжсан 92.4 сая төгрөгийн авлагыг төлүүлэх тал дээр арга хэмжээ авч ажиллах. НӨАТ-ын тооцоонд үлдэгдэлтэй байгаа харилцагчтай тооцоо нийлж, худалдан авалтын НӨАТ-ыг шивүүлж, НӨАТ-ын тайланд тусгах арга хэмжээ авах төдийгүй цаашид мөнгө шилжүүлсэн харилцагчдаас НӨАТ-ыг ebarimtad цаг хугацаанд нь бүртгүүлэх тал дээр зохион байгуулалтын арга хэмжээ авах.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Аудитын хүрээнд урьдчилгаа авсан боловч ажилаа гүйцэтгээгүй он дамжсан 92.4 сая төгрөгийг авлагын дансад ангилан бүртгэсэн. Мөн энэ онд авлага барагдуулах төлөвлөгөө гарган авлага барагдуулахад анхааран холбогдох байгууллагуудтай хамтран авлага барагдуулахад анхаарч ажиллах болно.	

НӨАТ-ын тооцоонд үлдэгдэлтэй байгаа харилцагчтай тооцоо нийлж, худалдан авалтын НӨАТ-ыг шивүүлж, НӨАТ-ын тайланд тусгах арга хэмжээ авах төдийгүй цаашид мөнгө шилжүүлсэн харилцагчдаас НӨАТ-ыг ebarimtad цаг хугацаанд бүртгүүлэх тал дээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах болно.

12. Гэрээт ажилчдын талаар	Тэргүүлэх ач холбогдол 2
<u>Бодит байдал</u> 2016 онд хөлсөөр ажиллах гэрээ 113-н хүнтэй байгуулан 1,046.0 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна. Гэрээт ажилчидтай байгуулсан гэрээг хугацаагаар ангилан авч үзвэл 3 ажилтантай 2-3 жилээр, 4 ажилтантай 1,5-2 жилээр, 4 ажилтантай 1-1,5 жилээр тус тус гэрээ байгуулсан байна. Компанийн 2016 оны батлагдсан орон тоо 1492, гүйцэтгэлээр 1477 байсан ба дээрх гэрээт ажилчид батлагдсан орон тоонд ороогүй бөгөөд эдгээр ажилчдад олгосон цалин хөлсийг их засварт бүртгэж байна.	
<u>Эрсдэл</u> Батлагдсан орон тоо хэтрүүлсэн, гэрээ оновчтой байгуулаагүй гэж үзэх	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Их засварын үед хөлсөөр ажиллах гэрээ байгуулдаг гэж байгаач гэрээт ажилтан байгаагийн үндэслэл, хэрэгцээ шаардлагыг эргэн хянах.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Тус компани нь их болон урсгал засварын ажлын үеэр хөлсөөр ажиллах гэрээгээр ажилчид ажиллуулдаг ба энэ оноос хийх ажлын эзэлхүүний шаардлагыг үндэслэн гэрээт ажилчдын хэрэгцээг тодорхойлон ажиллуулах болно.	

13. Ажилтны цагийн бүртгэл	Тэргүүлэх ач холбогдол 3
<u>Бодит байдал</u> Цалингийн тооцооны хүснэгтэд тусгагдсан буюу цалин бодоход ашигласан ажилласан цагаас түүвэрлэн авч цаг бүртгэлийн ERP программаас гарч буй ажилласан цагийн мэдээлэлтэй тулган харьцуулан шалгахад хоорондоо зөрүүтэй, ERP программын мэдээллийг үндэслэн шууд ажилласан цагийг тооцох боломжгүй, цех тасаг бүрд 1 ажилтан цаг бүртгэлийг тусд нь бүртгэж, ажилласан цагийн мэдээг санхүүд бэлтгэн өгч байгаа нь ERP программын цаг бүртгэлийн программыг хангалттай хэмжээнд зөв ашиглахгүй байна гэж үзэхээр байна. ERP программаас гарч буй мэдээллээс харахад нэвтэрч орсноос 3 өдрийн дараа гарсан, зарим өдөр орсон боловч гарсан мэдээлэл байхгүй аль эсвэл эсрэгээр нэвтэрч орсон мэдээлэлгүйгээр зөвхөн гарсан мэдээлэл бүртгэгдсэн зэрэг шууд боловсруулалт хийх боломжгүй байдалтай байсан.	
<u>Эрсдэл</u> Цагийн бүртгэлд тавих дотоод хяналт суларч илүү цагийн бүртгэлд зөрүү гарах эрсдэлтэй.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Цаг бүртгэлийн ERP программын хэрэглээг сайжруулж, цалин тооцоолоход ашиглаж буй цагийн мэдээллийг ERP программаас гарч буй мэдээлэлтэй тулгаж цагийн бүртгэлд хийх хяналтыг сайжруулах.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> ERP программын цаг бүртгэлийн системийн модулийг цаашид улам хөгжүүлж, цалингийн системтэй холбон цаг бүртгэлийн ERP программын хэрэглээг сайжруулж, цалин тооцоолоход ашиглаж буй цагийн мэдээллийг ERP программаас гарч буй мэдээлэлтэй тулгаж цагийн бүртгэлд хийх хяналтыг сайжруулан, мэдээллийг үнэн зөв гаргуулж, цалингийн бүртгэлтэй холбох талаар анхаарч ажиллана.	

14. Ажлаас халагдсаны тэтгэмжүүдийн тухайд	Тэргүүлэх ач холбогдол 3
<u>Бодит байдал</u> Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1-р заалтын дагуу ажлаас халагдсаны тэтгэмж олгохдоо ихэнх ажилтанд 3 сарын, зарим нэр бүхий цөөн тооны ажилтанд 6, 12 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж тооцож олгосон байгаа бөгөөд энэ нь ямар үндэслэлээр 3,6,12 сарын тэтгэмж олгож байгаа нь тодорхойгүй байна. Мөн 2016 оны 1-р сард Захиргаа хүний нөөцийн албаны менежер, 2016 оны 12 дугаар сард Эдийн засаг санхүүгийн албаны Санхүүгийн менежерийг “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний 12.10-р заалт (ажлын байр, орон тоо хасагдсан)-ыг үндэслэн ажлаас чөлөөлж 12-24 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийн олгосон. Гэсэн хэдий ч компанийн 2016 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээнээс харахад Захиргаа хүний нөөцийн алба 12 орон тооны ажилтан төлөвлөснөөс гүйцэтгэлээр 13 ажилтан ажилласан, Эдийн засаг санхүүгийн алба 18 орон тооны ажилтан төлөвлөснөөс гүйцэтгэлээр 18 ажилтан ажилласан байгаа нь орон тооны цомхотгол хийгээгүй нь харагдаж байна.	
<u>Эрсдэл</u> Үндэслэлгүй тушаал гаргаж тэтгэмж олгон компанийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж эрх бүхий байгууллагаас үзэх эрсдэлтэй байна.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Ажлаас халагдсаны тэтгэмж олгох хугацааг тодорхой болгох, тэтгэмжийг хууль, журамд нийцүүлэн үндэслэлтэй олгох	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Хамтын гэрээнд ажлаас халагдсаны тэтгэмж олгох хугацааны талаар тодорхой санал боловсруулан 2016-18 онд мөрдөх хамтын гэрээний 15.3 дах заалтыг үндэслэн өөрчлөлтийг оруулах болно. Мөн хууль, журамд нийцүүлэн тэтгэмжийг үндэслэлтэй тогтоож ажиллах болно.	

15. Татварын эрсдэл	Тэргүүлэх ач холбогдол 3
<u>Бодит байдал</u> “Дулааны дөрөвдүгээрцахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу ажилтанд олгосон сувиллын хөнгөлөлт, ажлаас чөлөөлөгдсөний тэтгэмжээс ХХОАТ суутгалгүй, нийт дүнгээр олгосон байна. Мөн актлахаар шийдвэр хүлээж буй ашиглалтгүй хөрөнгөд байгуулсан 37.6 сая төгрөгийн элэгдлийг татвар ноогдох орлогоос хасагдах зардлаар тооцож байна.	
<u>Эрсдэл</u> Нөхөн татвар, торгууль хүлээх эрсдэлтэй.	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Дээрх тэтгэмж нь ХХОАТ-ын тухай хуулийн дагуу татвар ногдох орлогоос чөлөөлөгдөх орлого болохгүй гэдгийг анхаарах. ААНОАТ-ын хуулиар орлого олох зорилгоор ашиглахаа зогсоосон хөрөнгийн элэгдлийг татвар ногдох орлогоос хасч тооцохгүй гэж заасаныг хэрэгжүүлэх.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Цаашид дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах болно.	

16. Эрчим зоогийн газрын үйл ажиллагааны талаар	Тэргүүлэх ач холбогдол 3
<u>Бодит байдал</u> Эрчим зоогийн газар нь 45 хүний бүрэлдэхүүнтэй өдрийн 2 ээлжээр ажиллаж, ажилчдад үйлчилдэг. 2016 онд Эрчим зоогийн газар нь 1,091.8 сая төгрөгийн орлого олж, 1,038.1 сая төгрөгийн материалын зардал, 1,268.4 сая төгрөгийн цалингийн зардал, 164.9 сая төгрөгийн НДШ-ийн зардал, 57.2 сая төгрөгийн гэрэл цахилгааны зардал тус тус зарцуулсан байна. Компани нь материалын зардлаас бусад зардлыг өртөгт тайлагнаж зоогийн газрын ашиг алдагдлыг зөвхөн материалын зардлаар тооцон гаргаж байна. НББОУС 18 “Орлого”-ын дагуу орлого, өртөг уялдах зарчмаар 2016 оны Эрчим зоогийн газрын үйл ажиллагаанаас олох ашиг алдагдлыг тооцон үзэхэд 1,436.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	
<u>Эрсдэл</u> Компанийн алдагдал өсөх	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Хоолны үнийг бодитой тооцох, өртөг зардлыг хэмжиж, компанийн алдагдлыг бууруулах бодлого барьж ажиллах.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Хоолны үнийг бодитой тооцох, эрчим зоогийн газрын өртөг зардлыг үндэслэлтэй тооцох талаар анхаарч ажиллана.	

17. Дэлгүүрийн бараа материалын худалдан авалт	Тэргүүлэх ач холбогдол 3
<u>Бодит байдал</u> 2016 онд дэлгүүрт 361.5 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Дэлгүүрийн худалдан авсан бараа материалыг нэр төрлөөр нь өссөн дүнгээр нэгтгэн харахад 100.6 сая төгрөгийн тамхи, 54.2 сая төгрөгийн ус, ундаа жүүс худалдан авсныг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу хийхээр байгаа энэхүү хуулийг мөрдөөгүй.	
<u>Эрсдэл</u> Хууль эрх зүйн актыг мөрдлөг болгоогүйгээс эрх бүхий байгууллага хариуцлага хүлээлгэх	
<u>Санал болгосон зөвлөмж</u> Дэлгүүрийн хэрэгцээт хүнсний материалыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу бэлтгэх.	
<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах болно.	

Санхүүгийн байдлын тайлан
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

(төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	2016 оны 4-р сарын 15-ны үлдэгдэл	Аудитлаагүй 2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	Залруулга (цэвэр дүнгээр)	Аудитлагдсан 2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,369,004,869.71	10,870,842,876.86		10,870,842,876.86
Дансны авлага	328,261,826.89	2,050,000.00		2,050,000.00
Татвар, НДШ-ийн авлага	-	54,765.91		54,765.91
Бусад авлага	140,819,044.11	141,752,613.49		141,752,613.49
Бараа материал	27,929,455.00	26,516,883.05		26,516,883.05
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	3,838,153.70	28,076,346.52		28,076,346.52
Эргэлтийн хөрөнгийн дүн	10,869,853,349.41	11,069,293,485.83	-	11,069,293,485.83
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	1,449,706,769.87	1,471,081,475.27		1,471,081,475.27
Биет бус хөрөнгө	29,245,972.95	22,421,414.32		22,421,414.32
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	889,577.30		889,577.30
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-		-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,478,952,742.82	1,494,392,466.89	-	1,494,392,466.89
ХӨРӨНГИЙН ДҮН	12,348,806,092.23	12,563,685,952.72	-	12,563,685,952.72
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	-	630,539.57		630,539.57
Татвар, шимтгэлийн өглөг	-	5,404,960.20		5,404,960.20
Богино хугацаатай зээлийн өглөг	-	-		-
Урьдчилж орсон орлого	10,951,100.00	11,676,805.00		11,676,805.00
Бусад богино хугацаат өр төлбөр	10,337,854,992.23	10,511,934,249.16		10,511,934,249.16
Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,348,806,092.23	10,529,646,553.93	-	10,529,646,553.93
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээлийн өглөг	-	-		-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-	-	-
Өр төлбөрийн нийт дүн	10,348,806,092.23	10,529,646,553.93	-	10,529,646,553.93
Эздийн өмч				
Хувьцаат капитал-Төрийн	2,000,000,000.00	2,000,000,000.00		2,000,000,000.00
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг				-
Дахин үнэлгээний нэмэгдэлийн нөөц				-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		34,039,398.79		34,039,398.79
Эздийн өмчийн дүн	2,000,000,000.00	2,034,039,398.79	-	2,034,039,398.79
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,348,806,092.23	12,563,685,952.72	-	12,563,685,952.72

Дэлгэрэнгүй орлогын тайлан
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны аудитлаагүй дүн	Залруулга (цэвэр дүнгээр)	Тайлант оны аудитлагдсан дүн
Борлуулалтын орлого	-	573,695,552.39		573,695,552.39
Борлуулалтын өртөг	-	208,149,331.93		208,149,331.93
Нийт ашиг (алдагдал)	-	365,546,220.46	-	365,546,220.46
Түрээсийн орлого	-	-		-
Хүүний орлого	-	154,789,040.86		154,789,040.86
Бусад орлого	-	914,891.00		914,891.00
Борлуулалт маркетингийн зардал	-	-		-
Ерөнхий удирдлагын зардал	-	460,257,988.65		460,257,988.65
Санхүүгийн зардал	-	-		-
Бусад зардал	-	11,519,001.21		11,519,001.21
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	45,140.42		45,140.42
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-		-
Бусад ашиг алдагдал	-	-		-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		49,518,302.88		49,518,302.88
Орлогын албан татварын зардал		15,478,904.09		15,478,904.09
Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)	-	34,039,398.79	-	34,039,398.79

Өмчийн өөрчлөлтийн тайлан

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2016 оны 4-р сарын 15-ны үлдэгдэл	2,000,000,000.00	-	-	-	2,000,000,000.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,000,000,000.00	-	-	-	2,000,000,000.00
Өмчид гарсан өөрчлөлт					-
Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн					-
Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)				34,039,398.79	34,039,398.79
2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,000,000,000.00	-	-	34,039,398.79	2,034,039,398.79

-

-

-

Мөнгөн гүйлгээний тайлан
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны аудитлаагүй дүн	Залруулга	Тайлант оны аудитлагдсан дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:		790,098,857,025.46		790,098,857,025.46
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого		594,176,569.20		594,176,569.20
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		7,322,515.00		7,322,515.00
Татаас санхүүжилтийн орлого		323,612,315.17		323,612,315.17
Бусад орлого		789,173,745,626.09		789,173,745,626.09
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:		789,695,002,919.59		789,695,002,919.59
Ажиллагчдад төлсөн мөнгө		312,326,369.86		312,326,369.86
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө		75,530,921.81		75,530,921.81
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө		16,323,162.71		16,323,162.71
Ашиглалтын зардалд төлсөн		8,734,060.12		8,734,060.12
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө		1,150,000.00		1,150,000.00
Төлсөн хүү				-
Төлсөн татвар		68,081,681.00		68,081,681.00
Даатгалын төлбөрт төлсөн		1,673,010.00		1,673,010.00
Бусад зардалд төлсөн мөнгө		789,211,183,714.09		789,211,183,714.09
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	403,854,105.87	-	403,854,105.87
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого				-
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө		(57,000,280.00)		(57,000,280.00)
Худалдсан хөрөнгө оруулалтын орлого				-
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		150,000.00		150,000.00
Хүлээн авсан хүүний орлого		154,789,040.86		154,789,040.86
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-	97,938,760.86	-	97,938,760.86
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-		-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		-		-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-		-
Төлсөн ноогдол ашиг		-		-
Санхүүгийн түрээсийн төлбөрт төлсөн		-		-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн ашиг (алдагдал)		45,140.42		45,140.42
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	-	45,140.42	-	45,140.42
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		501,838,007.15	-	501,838,007.15
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		10,369,004,869.71	-	10,369,004,869.71
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,870,842,876.86	-	10,870,842,876.86